

## РАДИОГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАХ ЗЭЭЛ, ҮЙЛЧИЛГЭНИЙ ХҮРТЭЭМЖ, ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ТАЛААРХ СУДАЛГАА


Өргөн нэвтрүүлгийн зохицуулалтын газрын мэргэжилтэн  
П.Золбоо

Радиоогийн үйлчилгээний хүртээмж олон улсад ямар нөхцөлд байгаа эсэхийг судлаачдын хийсэн судалгаа, дүгнэлтээс үзэхэд радио сонсогчийн зах зээлийн эзлэх хувь медиа зах зээлд телевиз үзэлтийн зах зээлтэй харьцуулахад хэдийгээр бага хувьтай байдаг ч тодорхой бөгөөд тогтвортой хувийг одоог хүртэл эзэлсээр байгаа нь радиоогийн үйлчилгээний эрэлтийг тодорхойлж байна. Радиоогийн үйлчилгээний хүртээмж сүүлийн жилүүдэд тогтвортой байгаа бөгөөд өндөр хөгжилтэй улс орны хувьд нийт хүн амын 85 хувь хамгийн багадаа долоо хоногт нэг удаа радио сонсдог гэсэн байх ба нийтдээ дэлхийн дээр 3 тэрбум орчим хүн долоо хоногт дор хаяж нэг удаа радио сонсдог байх статистик байгаа юм. Дэлөйт Глобал судалгааны байгууллагын судалгаагаар дэлхийн улс орнуудын дундаж үзүүлэлтээр том хүн өдөрт дунджаар 90 минут радио сонсдог бөгөөд нийт 18-34 насны залуучуудын 90 хувь нь долоо хоногт нэг удаа радио сонсдог буюу өдөрт дунджаар 80 минут радио сонсдог гэсэн дүгнэлтийг гарсан байна. Медиа зах зээлийн дийлэнх хэсгийг бүрдүүлж ирсэн телевизийн зах зээлийн хувьд телевизийн үзэлт сүүлийн жилүүдэд тогтвортой буурсан үзүүлэлттэй байгаа (Англи улсад 2018 онд 3 цаг 12 минут байсан бол 2019 онд 3 цаг 3 минут болсон, АНУ-ын 18-34 насны залуучуудын телевиз үзэлтийн хувь радиотой харьцуулахад 3 дахин буурсан буюу телевизийн үзэлт 2014 онд 3 цаг 50 минут байсан бол 2018 онд 3 цаг 25 минут болсон, радиоогийн хувьд 100 минутаас 96.5 минут болсон) бол радиоогийн зах зээлийн хувьд сонсогчдын хувь харьцангуй тогтвортой хэвээр байгаа (Англи улсад 2019 онд хүртээмж 89.4 хувь байсан бол 2020 онд 88.8 хувь болсон) нь радиоогийн үйлчилгээ, зах зээлийн ялгаатай байдлыг харуулж байна.

Судлаачдын үзэж байгаагаар радиоогийн үйлчилгээ нь цаашид тодорхой хэрэглэгчийн зорилтот сегмент байдлаар оршсоор байх бөгөөд өнөөдрийн байдлаар радиоогийн үйлчилгээний хүртээмжийн бодит нөөц боломжийг дутуу харж тооцоолох нь учир дутагдалтай гэж дүгнэжээ. Сонсогчийн судалгааг сонсогч өөрөө өдрийн тэмдэглэл байдлаар хөтлөх болон тухайн сонсогчоос хамааралгүйгээр технологийн арга ашиглан тандан судалсан хэрэглээний зан төлөвийн судалгааны 2 аргачлалаар хийсэн тайлангаар хүнээс хамаарсан судалгааны дүн радиоогийн үйлчилгээний хэрэглээг харьцангуй бууруулж дүгнэсэн буюу хүн өөрийнхөө бодож байснаас илүү цагаар радио сонсдог болох нь нотологдсон байна. График-1

Радио сонсогчийн сонсолтын түүвэр судалгааг АНУ-д хүнээс хараат бус технологийн аргаар Нейлсон Глобал Медиа компани зах зээлийн газар зүйн хил хязгаарыг тогтоосон голлох 48 зах зээлд хийдэг бөгөөд жижиг зах зээлд өдрийн тэмдэглэлийн арга ашиглах аргаар хийдэг байна. АНУ-д жилд 400.000 иргэн радио сонсогчийн судалгаанд хамрагддаг тоо байна.

График-1: Радиоогийн хүртээмжийн бодит байдал, харьцуулсан судалгаа. Эх сурвалж: Нейлсон, Дэлөйт судалгаа, АНУ, 2018 он




Дэлхийн радио зах зээлийн орлогын талаас дээш хувийг АНУ-ын зах зээл дангаараа бүрдүүлдэг ба түүний араас Герман, Хятад, Англи зэрэг улс орон жагсаалтыг тэргүүлж байна. Канад улсын хувьд радиогийн үйлчилгээний хүртээмж нийт хүн амын 86 хувьд хүрсэн байгаа бол радиогийн зах зээлийн нийт орлого 1.75 тэрбум ам.доллар буюу дэлхийд 4-т, нэг хүнд ногдох орлогын хэмжээ жилд 48 ам.доллар буюу дэлхийд 2-т тус тус эрэмблэгдэж байна. Сүүлийн жилүүдэд Канадын радиогийн үйлчилгээний нийт орлогын хэмжээ 1 хувиар буурсан хэдий ч хиймэл дагуулын радиогийн үйлчилгээний орлогын хэмжээ 6 хувиар өссөн байх жишээтэй. Англи улсын хувьд 2018 онд радиогоор нэвтрүүлж байгаа зар сурталчилгаан хэмжээ 12.5 хувиар нэмэгдсэн байх бөгөөд энэ нь интэрнэтээр нэвтрүүлэх зар сурталчилгааны хэмжээнээс давсан байна.

Зар сурталчилгаа нийлүүлэгчдийн хувьд радиогоор зар сурталчилгаа нэвтрүүлэх нь нийт хүн амын 80-90 хувьд шууд хүрэх, төлбөргүй үйлчилгээ гэдгээрээ ач холбогдолтой хэвээр байна. Дэлоит Глобал 2018 оны судалгаагаар тухайн хүний боловсролын түвшин, ажил эрхлэлтийн байдал болон орлогын түвшин радио сонсоход нөлөөлдөг байх боломжтой талаар дурдсан байна. Тухайлбал, ажил эрхэлдэг судалгаанд оролцогчдын 71 хувь нь, ажил эрхэлдэггүй судалгаанд оролцогчдын 61 хувь нь радио сонсдог, бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй оролцогчдын 74 хувь, коллеж төгссөн оролцогчдын 62 хувь, бүрэн дунд боловсролтой оролцогчдын 56 хувь нь радио сонсдог, 75.000 ам доллараас дээш орлоготой оролцогчдын 75 хувь, 45.000-75.000 ам долларын орлоготой оролцогчдын 68 хувь, 25.000 ам доллараас доош орлоготой оролцогчдын 50 хувь нь радио сонсдог гэсэн мэдээ гарсан байна. Харин судалгаанд оролцогчдын хувьд радиог гол төлөв машиндаа сонсдог (89-93%) гэсэн бол удаах нь гэртээ (42-53%) болон ажил дээрээ (16-30%) сонсдог гэсэн байна.


Зар сурталчилгаа нийлүүлэгчдийн хувьд болон тухайн радиогийн салбарын хөгжлийг тодорхойлох шалгуур нь нэг хүнд ногдох орлогын хэмжээ байх бөгөөд АНУ-ын тухайнд нэг хүнд ногдох радиогийн салбарын орлого жилд 67 ам доллар буюу дэлхийд нэгдүгээрт орж байна. Манай улсын хувьд нэг хүнд ногдох радиогийн салбарын орлого жилд 0.11 ам доллар байгаа нь Энэтхэг (0.3 ам доллар), Нигер (0.4 ам доллар) улстай ойролцоо түвшинд байна. Энэхүү үзүүлэлт нь дэлхийн хэмжээнд харьцуулахад бага байгаа ч хүн амын тоо, нягтрал, нэг хүнд ногдох ДНБ-ний хэмжээ (Энэтхэг улсын нэг хүнд ногдох ДНБ 2,099.60 ам доллар, Нигер улсын хувьд 2,229.86 ам доллар, Монгоол улсын хувьд 4,339.84 ам доллар, 2019 он) зэрэг эдийн засаг, хүн ам зүйн үзүүлэлтийн хүрээнд бага дүн биш бөгөөд зах зээлийн багтаамж байх боломжтойг илтгэж байна. График-2

График-2: Нэг хүнд ногдох радиогийн үйлчилгээний зэх зээлийн нийт орлого, радиогийн үйлчилгээний хүртээмжийн харьцаа. Эх сурвалж: Англи, Канад улсын харилцаа холбооны салбарын статистик үзүүлэлт, аналитик судалгаа, 2017 он



Дэлхийн радиогийн зах зээлийн хэмжээ 40 гаран тэрбум ам доллартай тэнцэж байгаагийн тал хувь нь АНУ-ын зах зээл гэж өмнө нь дурдсан бөгөөд манай улсын хувьд радиогийн зах зээлийн хэмжээ бусад улстай харьцуулахад харьцангуй бага, жилд дунджаар 388.000 ам доллар (ҮСХ-ны дата, 2020 он) байна. График-3

График-3: Радиогийн үйлчилгээ зах зээлийн орлогын хэмжээ, Топ-10 улс орон. Эх сурвалж: Англи, Канад улсын харилцаа холбооны салбарын статистик үзүүлэлт, аналитик судалгаа, 2017 он



Дээрх график-2, график-3-д дурдсан мэдээллээс харахад тухайн орны радиогийн зах зээлийн нийт орлого, нэг хүнд ногдох орлогын түвшин нь радиогийн үйлчилгээний хүртээмжтэй шууд хамааралтай гэж үзэх нь хангалтгүй байна. Тухайлбал, Польш улсын радиогийн хүртээмж 96 хувьтай байхад радиогийн орлогын нэг хүнд ногдох орлого нь 4 ам доллар, Герман улсын радиогийн хүртээмж харьцангуй дундаж түвшинд буюу 68 хувьтай байхад нэг хүнд ногдох орлого 46 ам доллар, дэлхийн радиогийн орлогын зах зээлд 2-т эрэмблэгдэж байна. Үүнээс дүгнэхэд манай улсад тухайн радиогийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, технологийн дэвшилд хөрөнгө оруулалт хийх чиглэлээр анхаарахаас гадна радиогийн зах зээлийн үнэлэмжийг нэмэгдүүлэх, зах зээл дээр брэнд бий болгох, салбарт манлайлах чиг үүрэгтэй голлох тоглогчид бий болох,

медиа зах зээлээс төвлөрүүлэх орлогын хувийг нэмэгдүүлэх боломж байсаар байгааг илтгэж байна.

Судлаачдын дүгнэлтээр зарим насны бүлгийн хүмүүсийн радио сонсдог шалтгаан нь шинэ хөгжим сонсох боломж байдаг бол зарим насныханд өөр шалтгаан байх жишээтэй. Радиогийн зах зээл нь стратеги төлөвлөлтийн хувьд маш нарийвчлалтай, хэрэглэгчийн сегментийг тодорхойлж зах зээлд ялгарал бий болгохыг шаарддаг тул радиогийн үйлчилгээ эрхлэгчдийн хувьд зах зээлд өрсөлдөхдөө үйл ажиллагааны стратегийг тодорхойлж, бизнесийн төлөвлөлтийг оновчтой тооцоолох нь чухал юм. (График-4)

График-4: Яагаад радио сонсдог вэ? Эх сурвалж: Дэлоит Глобал судалгаа, 2018 он

№	Радио сонсох шалтгаан, үндэслэл:	18-34 нас	35-54 нас	55-75 нас
1	Хөтлөгчийн яриа, харилцаа таалагддаг	24%	25%	24%
2	Шинэ дуу, хөгжим сонсох	36%	25%	19%
3	Суулгах, татаж авах шаардлагагүй	28%	30%	41%
4	Мэдээтэй	22%	33%	38%
5	Интернэтэд холбогдох шаардлагагүй	37%	28%	36%
6	Олон талын хөтөлбөр, контенттой	30%	33%	38%
7	Ашиглахад хялбар	37%	45%	45%
8	Шууд хөтөлбөр, амьд харилцаатай	34%	47%	55%
9	Машиндаа сонсох боломжтой	50%	51%	62%
10	Үнэгүй	57%	61%	66%

Радиогийн үйлчилгээ нь үйлчилгээ талаасаа “үнэгүй хүлээн авах боломжтой гэдэг утгаараа радиог их сонсдог” гэсэн хариулт хамгийн өндөр буюу бүх насны ангилалд хамгийн өндөр, 57-66 хувьтай өгсөн байгаа бол үүний араас “шууд хөтөлбөр дамжуулдаг, хөтлөгчтэй, сонсогчидтой амьд харилцаа үүсгэдэг” гэдэг хариултыг 50 хувь нь өгсөн байна. Харин 18-34 насныханы хувьд радиогоор нэвтрүүлэх мэдээ, мэдээллийн хөтөлбөр төдийлөн ач холбогдолтой бус (22%) байдаг бол 35-54 нас (33%), 55-75 насны (38%) хүмүүсийн хувьд мэдээ чухал байгаа нь харагдаж байна. Эсрэгээрээ 18-34 насныханы хувьд радиогоор шинэ дуу, хөгжим сонсох нь ач холбогдолтой (36%) байдаг бол 35-54 нас (25%), 55-75 насны (19%) хүмүүсийн хувьд нэн чухал бус байна.

#### Монгол Улсын хувьд:

Харилцаа холобооны зохицуулах хороо нь өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдэд тусгай зөвшөөрөл олгож тэдгээрийн үйл ажиллагаанд техникийн болон үйлчилгээний холбогдох нөхцөл, шаардлагуудыг тавьж ирсэн. Зохицуулах байгууллагын хувьд радио давтамжийн хязгаарлагдмал нөөц, олон улсын стандарт, шаардлагын дагуу нөөцийг оновчтой хуваарилах, шударга, үр ашигтай ашиглах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор анхны өргөн нэвтрүүлгийн үйлчилгээтэй холбоотой зохицуулалтыг хийж эхэлсэн бол сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд хэрэглэгч, сонсогчдод хүргэх хөтөлбөрт тодорхой шаардлагуудыг тавьж, хэрэгжилтийг хангуулахад анхаарах шаардлага бий болсон.

Хүн амын хөдөлгөөн байнгын хийгдэж байгаа сүүлийн 30 жилийн турш Улаанбаатар хотод хүн ам ихээр сууршин төвлөрсөн. Үүнийг дагаад худалдаа үйлчилгээний төвлөрөл Улаанбаатар хотод нэмэгдсэний нэг жишээ нь тусгай зөвшөөрлийн олголтын тоо юм. Улаанбаатар хотын хэмжээнд өнөөдрийн байдлаар нийт

33 арилжааны радио үйл ажиллагаа явуулахаар тусгай зөвшөөрөл авсан байгаа бол энэ тоо 4-5 жилийн өмнө 23 байсан. Нийслэл хотод радиогийн тусгай зөвшөөрөл 43%-р нэмэгдсэн байхад орон нутагт эсрэгээрээ энэ тоо 3 дахин буурсан байх ба зарим аймагт радиогийн үйлчилгээ эрхлэгч огт байхгүй байна.

Тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа эрхлэх нутаг дэвсгэр буюу хамрах хүрээг зааж өгдөг бөгөөд энэхүү хамрах хүрээг хүсэлт гаргаснаар нэмэгдүүлэх, өөр аймаг, сум, суурин газарт үйлчилгээ явуулах, хөтөлбөрөө дахин дамжуулах боломжтой болдог. Энэ зарчмаар Улаанбаатар хотын 4-5 радио өөрийн үйлчилгээний хамрах хүрээг нийлбэр дүнгээр 62 нутаг дэвсгэрт өргөжүүлж, зарим нь шууд 21 аймагт хөтөлбөр дамжуулах боломжтой болсон байна. Хамрах хүрээ нэмэгдүүлэх тохиолдолд үйлчилгээний тусгай зөвшөөрөлд нэмэлт хийлгэхээс гадна тухайн орон нутагт радио давтамж ашиглах тусгай зөвшөөрөл авах хүсэлтийг хамт гаргасан байх шаардлагатай байдаг. Хамрах хүрээ нэмсэн радиогийн хувьд зарим нь тухайн орон нутагт хөтөлбөрийг зөвхөн дахин дамжуулах байдлаар, өөрөөр хэлбэл тухайн орон нутгийн зар сурталчилгааны зах зээлд оролцоогүй байдлаар үйл ажиллагаа явуулж байна. Зарим тохиолдолд тухайн орон нутагт ажлын байр бий болгон, хөтөлбөр бэлтгэн, зар сурталчилгааны зах зээлд оролцоотой байдлаар ажиллаж байна. (Хүснэгт-1)

Радиогийн үйлчилгээ нь уламжлалт бизнесийн тогтолцоогоор зар сурталчилгааны орлогоор санхүүждэг бөгөөд сонсогч үнэ төлбөргүй хүлээн авах боломжтой үйлчилгээ юм. Энэ ч утгаараа радиогийн үйлчилгээ нь олон улсад олон нийтийн болон арилжааны статустай байхаас гадна хүйн (community) гэсэн статустай байдаг. Сүүлийн жилүүдэд интернэтийн хурд, хэрэглээ, дэд бүтэц сайжирсанаар интернэтэд суурилсан үйлчилгээ зах зээлд нэвтэрч байгаагийн нэг жишээ нь интернэт радио, подкаст радио билээ. Нийслэлийн статистикийн газрын 2016, 2017 оны тайланд *“Улаанбаатар хотын хэмжээнд нэвтрүүлгээ цацаж буй радиогийн тоонд 2017 онд өөрчлөлт ороогүй буюу 23 радио үйл ажиллагаа явуулж байна. Эдгээрээс 11 радиог онлайнгаар шууд, 8 радиог ухаалаг утасны аппликейшн ашиглан сонсох боломжтой бол МҮОНР-г фейсбүүк дэх MNB Live-аар дүрстэй үзэх боломжтой юм”*<sup>1</sup> гэжээ.

Олон улсад уламжлалт радиогийн үйлчилгээний бизнес загвар өөрчлөгдөж байгаагийн жишээ нь интернэтээр радио хөтөлбөр дамжуулснаар эцсийн сонсогчоос төлбөр авах, үйлчилгээний тарифтай, суурь хураамжтай үйлчилгээний төрөл бий болсон. Энэ нь радиогийн үйлчилгээ эрхлэгчдийн хувьд бизнесээ өргөжүүлэх, орлогоо нэмэгдүүлэх боломжийг бий болгохын зэрэгцээ техник технологийн сүүлийн үеийн чиг хандлага, шийдлийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, зорилтот зах зээлийн сегментэд чиглэсэн хөтөлбөр, контент бэлтгэн хүргэх, сонсогчидтой амьд харилцаа үүсгэх сорилтыг мөн бий болгож байна.

Манай улсын хувьд үүрэн холбоо, интернэтийн нэвтрэлт хэдийгээр өндөр хувьтай байгаа гэсэн статистик байгаа ч Монгол улсын нутаг дэвсгэрийг бүхэлд нь хамарсан, тасралтгүй сүлжээ хараахан нэвтрээгүй байна. Орон нутагт аялангаа авто замын дагуу тасралтгүй радио сонсоод, интернэтэд холбогдож явах боломж хараахан үүсээгүй байгаа тул хүн ам төвлөрсөн аймаг, нийслэл, сум, суурин газруудад л интернэт радио хөгжих бололцоотой байна. Гадаадын зарим улсад хиймэл дагуулаар радиогийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон байх ба тусгай хүлээн авах төхөөрөмж машиндаа суулган байршлаас үл хамааран радиогийн хөтөлбөрийг тасралтгүй хүлээн

---

<sup>1</sup>Монгол Улсын нийслэлийн эдийн засаг, нийгмийн байдал 2016, 2017 он  
[file:///C:/Users/413/Downloads/jiliin\\_taniitsuulga\\_2016\\_ulaanbaatar\\_2018-01.pdf](file:///C:/Users/413/Downloads/jiliin_taniitsuulga_2016_ulaanbaatar_2018-01.pdf)

авах боломжтой байдаг байна. Мөн автомашин үйлдвэрлэгч улсуудын хувьд үйлдвэрлэгчтэй гэрээлж автомашиныг үйлдвэрлэх явцад тухайн төхөөрөмжийг суулгаж өгөх жишээ ч байна.

Зохицуулах хорооноос гаргасан тусгай зөвшөөрлийн статистик (хүснэгт-1) тоогоор радиогийн үйлчилгээ эрхлэгч байхгүй 10 аймаг байгаа бол эдгээр аймагт Улаанбаатар хотын 3-4 радиогийн үйлчилгээ эрхлэгч хамрах хүрээгээ өргөжүүлсэн байна. Радиогийн үйлчилгээ нь өөрөө онцлог үйлчилгээ бөгөөд тухайн нэг хамрах хүрээнд үйл ажиллагаа эрхэлж, сонсогчидтой ойр байх, амьд харилцаа үүсгэж, орон нутгийн мэдээ мэдээлэл бэлтгэж хүргэх нь ач холбогдолтой, хандалт их авдаг. Харин үйлчилгээний хамрах хүрээ нэмэгдэхийн хирээр үйлчилгээний бодит хүртээмж, харилцаа буурдаг. Энэ ч онцлог шинжээсээ хамаарч олон улсад маш олон радиогийн тусгай зөвшөөрөлтэй үйлчилгээ эрхлэгч, олон төрлийн брэндийг бий болгож, олон янзын сегментэд хүрч ажиллаж байгаа гэж дүгнэдэг.

Хүснэгт-1: Хүн ам, нягтрал, үйлчилгээ эрхлэгчдийн тоо. Эх сурвалж: ҮСХ-ны мэдээллийн сан, ХХЗХ-ны ЗЗҮТҮСГазар

№	Аймаг, нийслэл, сум, дүүрэг	Хүн ам (ҮСХ) 2019 он	Өрхийн тоо (ҮСХ) 2019 он	Хүн амын нягтрал (ҮСХ) 2019 он	ТЗ тоо (ХХЗХ) 2020 он	Хамрах хүрээ нэмсэн радио (ХХЗХ) 2020 он	Бүгд	Нэг радиод ногдох хүн амын тоо
1	Улаанбаатар	1466125	411420	327.6	33		33	44,428
2	Багануур	28570	8133	327.6	1		1	28,570
3	Налайх	37659	10248	290.7	1	1	2	18,830
4	Архангай аймгийн төв	21517	6045	143.4		3	3	7,172
5	Баян-өлгий аймгийн төв	37326	8486	369.9		2	2	18,663
6	Баянхонгор аймгийн төв	31731	9284	495.8		2	2	15,866
7	Булган аймгийн төв	12484	3612	124.9	1	2	3	4,161
8	Говь-алтай аймгийн төв	18444	5210	8.5		2	2	9,222
9	Говьсүмбэр аймгийн төв	12704	3634	3.4	1	2	3	4,235
10	Дархан -уул аймгийн төв	85303	24305	827	6	4	10	8,530
11	Шарын гол	7809	2016	48.6		1	1	7,809
12	Хонгор	5861	1535	2.3		1	1	5,861
13	Орхон	3198	941	6.7		1	1	3,198
14	Дорноговь аймгийн төв	25910	7281	11.1	2	3	5	5,182
15	Замын-үүд	18804	4861	38.6		1	1	18,804
16	Дорнод аймгийн төв	46221	12600	164.6	1	3	4	11,555
17	Дундговь аймгийн төв	15764	4737	4.6		2	2	7,882
18	Завхан аймгийн төв	16232	4568	577.7	3	2	5	3,246
19	Тосонцэнгэл	9303	658	0.3	1		1	9,303
20	Орхон аймгийн төв	100639	27405	169.1	4	4	8	12,580
21	Жаргалант	3393	981	13.6		1	1	3,393
22	Өвөрхангай аймгийн төв	32891	9235	190.1	3	3	6	5,482
23	Өмнөговь аймгийн төв	26367	8200	55.4	1	3	4	6,592
24	Ханбогд	8660	1956	0.6	1		1	8,660
25	Сүхбаатар аймгийн төв	21852	6093	401		3	3	7,284
26	Сэлэнгэ аймгийн төв	22578	5831	497.9		3	3	7,526
27	Мандал	27011	6944	5.6	1		1	27,011

28	Төв аймгийн төв	16677	4711	869.5		2	2	8,339
29	Увс аймгийн төв	31652	8578	12.2		3	3	10,551
30	Ховд аймгийн төв	30777	7960	424.3	2	3	5	6,155
31	Хөвсгөл аймгийн төв	40770	11687	396.2	1	3	4	10,193
32	Хэнтий аймгийн төв	23765	6987	6.2		2	2	11,883

Энэхүү судалгаагаар радиогийн үйлчилгээний нягтралыг тухайн нутаг дэвсгэр дэх хүн амын тоо, үйлчилгээний хамрах хүрээнд харьцуулж тодорхойлохыг зорив. (Хүснэгт-1) Радиогийн үйлчилгээний нягтрал буюу нэг радиод ногдох хүн амын тоо нь улсын хэмжээнд 25,576 байна. Радиогийн үйлчилгээ хүрч байгаа аймаг, нийслэл, сум, зарим дүүргийн хэмжээнд радиогийн үйлчилгээний нягтралыг тооцож үзэхэд Улаанбаатар хот, Багануур дүүрэг, Мандал суманд улсын дунджаас их, бусад 29 сум, сууринд үйлчилгээний нягтрал улсын дунджаас бага байдалтай байна.

Улс орнуудын радиогийн зах зээлийн хөгжлийг тодорхойлох, зар сурталчилгаа нийлүүлэгчдийн хувьд маркетингийн төлөвлөлт хийх нэг үндсэн үзүүлэлт нь тухайн нутаг дэвсгэрийн хүрээнд нэг хүнд ногдох орлогын хэмжээ байх бөгөөд олон улсад энэ үзүүлэлтээр дэлхийн радиогийн зах зээлийн рейтинг, орлогын түвшинг тооцоолж үздэг байна. (Хүснэгт-2) Радиогийн зах зээлээс олох нэг хүнд ногдох орлого улсын дунджаар 318 төгрөг байгаа бол орон нутгийн дунджаар 73 төгрөг тус тус байна. Манай улсын хувьд энэ үзүүлэлт нь хэдийгээр дэлхийн түвшингээс доогуур байгаа ч Үндэсний статистикийн хорооны тайлангаас үзэхэд “Тээвэр, мэдээлэл холбоо”-ны салбарын Монгол улсын ДНБ-д эзлэх оролцооны хувь хэмжээ нь дэлхийн улс орнуудтай харьцуулахад зэрэгцээ түвшинд байна<sup>2</sup>.

Радиогийн үйлчилгээний нэг хүнд ногдох орлогны хэмжээ 2019 оны статистик дүнгээр Улаанбаатар хотын хэмжээнд 606 төгрөг байгаа бол Дархан-Уул аймагт 515 төгрөг, Дорноговь аймагт 1598 төгрөг тус тус байна. Тусгай зөвшөөрөлтэй үйлчилгээ эрхлэгчтэй бусад 9 аймгийн хувьд нэг хүнд ногдох радио үйлчилгээний орлого нь улсын дунджаас доогуур боловч эдгээрийн 7 нь орон нутгийн дунджаас дээгүүр үзүүлэлттэй байна. Үйлчилгээний хамрах хүрээнээсээ хангалттай хэмжээний орлого төвлөрүүлж чадахгүй байгаа дүр зураг орон нутаг байгаа бол Улаанбаатар хотод нийгэм эдийн засгийн бүхий л салбарын төвлөрөл (ДНБ-ний 66% УБ хотод, 33% нь орон нутагт) үүссэний баталгаа үүгээр харагдаж байна. Дархан-Уул, Дорноговь аймгуудын хувьд нэг хүнд ногдох орлогын түвшин улсын дундажтай харьцуулахад өндөр байгаа нь тухайн орон нутгийн онцлог, үйлчилгээ эрхлэгчдийн тоо, санхүүгийн бүртгэл тооцооны үнэн бодит байдал зэрэг олон нөхцөл байдлаас хамаарсан байх боломжтой тул өмнөх онуудын статистик мэдээллийг харьцуулж харах эсхүл жил бүр судалгаа хийх замаар илүү нарийвчилсан байдлаар дүгнэх нь зүйтэй юм.

Хүснэгт-2: Нэг хүнд ногдох радиогийн үйлчилгээний орлого. Эх сурвалж: ҮСХ-ны мэдээллийн сан, ХХЗХ-ын ЗЗҮТҮСГазар

№	Аймаг, нийслэл, сум, дүүрэг	Радиогийн ҮЭ-ийн Орлого 2019 он (мянган төг)	Нэг хүнд ногдох радио үйлчилгээний орлого 2019 он (төгрөг)
1	Улаанбаатар	889,811	606.91
2	Баянхонгор аймгийн төв	1,257	39.60
3	Булган аймгийн төв	300	24.03


<sup>2</sup> OECD ICT investment as a percentage in GDP 2017

4	Дархан -уул аймгийн төв	43,979	515.56
5	Дорноговь аймгийн төв	41,420	1,598.59
6	Дорнод аймгийн төв	7,809	168.95
7	Завхан аймгийн төв	1,600	98.57
8	Орхон аймгийн төв	17,771	176.58
9	Өвөрхангай аймгийн төв	2,000	60.81
10	Өмнөговь аймгийн төв	2,500	94.82
11	Ховд аймгийн төв	6,275	203.89
12	Хөвсгөл аймгийн төв	4,434	108.75

Радиоогийн үйлчилгээний нэг хүнд ногдох орлогын хэмжээг ҮСХ-ны хүн амын тоо, ҮСХороо болон ХХЗХ-ны ЗЗҮТҮСГ-с гаргасан радиоогийн үйлчилгээний жилийн орлогын дата мэдээнд тулгуурлан харьцуулж дараах байдлаар үзүүлэв. (График-1)

Радиоогийн үйлчилгээний нэг хүнд ногдох орлогын хэмжээг тухайн хамрах хүрээнд үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй болон хамрах хүрээг нэмэгдүүлсэн радиоогийн тоонд харьцуулсан бөгөөд Улаанбаатар хотод ажиллаж байгаа 33 радиоогийн тухайд нэг хүнд ногдох орлогын хэмжээг бусад орон нутгийн орлогын хэмжээтэй харьцуулав. Тухайлбал, Дорноговь, Завхан, Ховд аймгуудад радиоогийн үйлчилгээ эрхлэгчийн тоо ижил хэмжээнд байхад орлогын түвшин харилцан адилгүй байх, зарим аймагт үйлчилгээ эрхлэгчдийн тоо олон боловч радиоогийн үйлчилгээний орлогын түвшин бага, зарим аймгуудад эсрэгээрээ байх зэрэг харилцан адилгүй нөхцөл байдалтай байна.

График-1: Нэг хүнд ногдох радиоогийн үйлчилгээний орлогын хэмжээ, хамрах хүрээгээр хийсэн харьцуулалт 2019 он. Эх сурвалж: ҮСХ, ХХЗХ-ны ЗЗҮТҮСГазар



Үндэсний статистикийн хорооны тайлангаар тухайн салбарын байр суурийг илтгэх чухал үзүүлэлт бол улс орны нийгэм эдийн засагт оруулах тухайн салбарын хувь нэмэр, оролцоо байдаг бөгөөд ДНБ-д эзлэх Харилцаа холбооны салбарын оролцоо, нэг хүнд ногдох ДНБ-д эзлэх оролцоог тодорхойлж салбарын үйл ажиллагааны багтаамжийг нэгж хүн дээрх үзүүлэлтээр тооцоолон харуулахыг зорив. Үндэсний статистикийн хорооны мэдээллийн санд тээврийн салбарын дүн харилцаа холбоотой хамт гарч



байгаа тул салбарын дүн мэдээг дангаар нь гаргах боломжгүй байв. Түүнчлэн харилцаа холбооны салбар дотор нь өргөн нэвтрүүлэг, радиогийн үйлчилгээ гэж ангилж харьцуулан гаргах бололцоо байхгүй байгаа тул энэ талаар цаашид тодорхой ажлууд хийхээр төлөвлөж байна.

Монгол Улсын нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ. (Хүснэгт-3)

Хүснэгт-3: МУ-ын ДНБ-ий хэмжээ. Эх сурвалж: Статистикийн мэдээллийн сан (мянган төгрөг)

Статистик үзүүлэлт	МУ-ын ДНБ	2016	2017	2018	2019	2020
Оны үнээр	1 хүнд ногдох ДНБ, мян.төг	7,910.0	8,999.1	10,259.8	11,680.6	11,459.5
Оны үнээр	1 хүнд ногдох ДНБ, ДБ-ны Атласын аргаар, ам доллар	3,853.6	3,780.0	4,050.1	4,317.4	4,167.0

Үндэсний статистикийн хорооны мэдээллээр Монгол улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 7%-ийг Тээвэр, Мэдээлэл Холбооны салбар бүрдүүлж байна. Энэхүү тоо нь сүүлийн жилүүдэд тогтвортой байгаа боловч бага зэрэг буурах хандлагатай байна. (ҮСХ: 2016 онд 7.4%, 2017 онд 6.9%, 2018 онд 6.7%, 2019 онд 6.6%)

Нийгэм, эдийн засгийн бүхий л үзүүлэлтээр Улаанбаатар хотод үйлчилгээний зах зээлийн төвлөрөл бий болсон байгаа бол орон нутагт ямар байгаа, тухайн орон нутгийн ДНБ-д эзлэх хувь хэмжээ ямар байгааг нээлттэй мэдээллээс авч үзэхэд тухайн аймаг, орон нутгийн ДНБ-д эзлэх тээвэр, мэдээлэл холбооны салбарын хувь нь улсын дундаж үзүүлэлтээс дээгүүр буюу 6.6%-с дээгүүр байгаа 5 аймаг байна. (Хүснэгт-4) Эдгээр аймгуудад дунджаар 1-2 радиогийн үйлчилгээ эрхлэгч байгаа бол Сэлэнгэ аймагт радио огт байхгүй байна. Гэхдээ анализ дүгнэлтийг тодорхой болгох зорилгоор тээврийн салбарын тоог харилцаа, холбооны салбарын тоон үзүүлэлтээс тусад нь харах шаардлага байна. Орхон аймагт радио, телевиз, ОСДҮЭ-ийн тоо бусад аймагтай харьцуулахад олон байдаг ч ДНБ-д эзлэх хувь хэмжээ нь маш доогуур 0,8% байгаа нь тодорхойгүй цааш нь нягтлах шаардлагатай гэж харагдаж байна. Улаанбаатар хотын хэмжээнд ДНБ-д эзлэх тээвэр, мэдээлэл холбооны салбарын эзлэх хувь нь улсын дунджаас өндөр 8.4% байна. Орон нутгийн хувьд 21 аймгийн ДНБ-д эзлэх тээвэр, мэдээлэл холбооны салбарын эзлэх хувь нь нийлбэр үзүүлэлтээр 3.1% буюу улсын дунджаас доогуур байна. Баян-Өлгий, Увс, Баянхонгор аймгуудын тухайд орон нутгийн дундаж үзүүлэлтээс дээгүүр хувьтай байгаа боловч эдгээр аймгуудад радиогийн тусгай зөвшөөрөл эзэмшигч байхгүй байна. Үүнээс дүгнэхэд орон нутгийн ДНБ-д эзлэх салбарын эзлэх хувь хэмжээ, тухайн орон нутгийн онцлог, макро эдийн засгийн бусад үзүүлэлтээс хамааран үйлчилгээ эрхлэгч нь зах зээлээс шаардлагатай орлогыг төвлөрүүлэх арга хэмжээг нөөц бололцооны хүрээнд хэрэгжүүлэх боломжтой гэж үзэж байна.

Хүснэгт-4: ДНБ-д эзлэх тээвэр, мэдээлэл, холбооны салбарын эзлэх хувь. Эх сурвалж: ҮСХ-ны статистикийн мэдээллийн сан

ДНБ		2016	2017	2018	2019
Улсын дүн	Тээвэр, мэдээлэл, холбоо	7.4%	6.9%	6.7%	6.6%
УБ хот	Тээвэр, мэдээлэл, холбоо	10.1%	9.4%	8.8%	8.4%
Баян-Өлгий	Тээвэр, мэдээлэл, холбоо	4.8%	5.6%	5.0%	4.5%
Говь-Алтай	Тээвэр, мэдээлэл, холбоо	0.9%	1.0%	0.9%	0.9%

Завхан	Тээвэр, мэдээлэл, холбоо	3.4%	4.1%	3.6%	3.1%
Увс	Тээвэр, мэдээлэл, холбоо	2.0%	2.4%	2.2%	2.2%
Ховд	Тээвэр, мэдээлэл, холбоо	3.2%	4.0%	3.6%	3.9%
Архангай	Тээвэр, мэдээлэл, холбоо	1.3%	1.4%	1.4%	1.1%
Баянхонгор	Тээвэр, мэдээлэл, холбоо	2.5%	2.7%	2.8%	2.5%
Булган	Тээвэр, мэдээлэл, холбоо	0.9%	1.1%	1.1%	0.9%
Орхон	Тээвэр, мэдээлэл, холбоо	1.2%	0.9%	1.0%	0.8%
Өвөрхангай	Тээвэр, мэдээлэл, холбоо	2.3%	2.5%	3.0%	2.8%
Хөвсгөл	Тээвэр, мэдээлэл, холбоо	1.8%	2.3%	2.0%	1.7%
Говьсүмбэр	Тээвэр, мэдээлэл, холбоо	0.4%	0.4%	0.5%	15.8%
Дархан-Уул	Тээвэр, мэдээлэл, холбоо	2.9%	3.2%	3.0%	11.6%
Дорноговь	Тээвэр, мэдээлэл, холбоо	12.6%	12.3%	10.1%	9.8%
Дундговь	Тээвэр, мэдээлэл, холбоо	1.9%	2.1%	1.6%	1.4%
Өмнөговь	Тээвэр, мэдээлэл, холбоо	5.2%	3.4%	7.4%	8.2%
Сэлэнгэ	Тээвэр, мэдээлэл, холбоо	2.4%	2.8%	2.5%	7.5%
Төв	Тээвэр, мэдээлэл, холбоо	0.5%	0.7%	0.6%	0.2%
Дорнод	Тээвэр, мэдээлэл, холбоо	0.7%	0.7%	1.1%	0.7%
Сүхбаатар	Тээвэр, мэдээлэл, холбоо	0.8%	0.6%	0.7%	0.7%
Хэнтий	Тээвэр, мэдээлэл, холбоо	0.9%	1.2%	1.0%	1.0%

Нэг хүнд ногдох ДНБ-ний хэмжээгээрээ улсын дундажтай ижил хэмжээнд байгаа 2 (Дорнод, Өмнөговь) аймаг, улсын дунджаас дээгүүр хэмжээнд, Улаанбаатар хотын үзүүлэлтээс өндөр 1 (Орхон) аймаг байна. (Хүснэгт-5) Эдгээр 3 аймгийн 2-ынх нь хувьд тухайн аймгийн нийт ДНБ-д эзлэх Тээвэр, мэдээлэл холбооны салбарын эзлэх хувь нь хэт бага байгаагийн хамаарлыг нарийвчлан тодорхойлох, тенденцийг судлах зэргээр зах зээлийн макро эдийн засгийн түвшний мэдээлэл гаргах мэдээллийн хэрэгцээ шаардлага үүсч байна.

Түүнчлэн нэг хүнд ногдох ДНБ, ДНБ-д эзлэх тээвэр, мэдээлэл холбооны салбарын хувийг ашиглан нэг хүнд ногдох ДНБ-д эзлэх тээвэр, мэдээлэл холбооны салбарын хувийг гаргаж үзэхэд нэг хүнд ногдох ДНБ-д эзлэх Тээвэр, мэдээлэл холбооны бүтээгдэхүүний оролцоо нь Улаанбаатар хотын хувьд улсын дундаж (774,000 төг)-аас 2 дахин их буюу 1,422,000 төгрөг, Говьсүмбэр аймагт 1,023,000 төгрөг, Өмнөговь аймагт 972,000 төгрөг тус тус байна. Зарим аймгуудад хувь хүнд ногдох тээвэр, мэдээлэл холбооны салбарын бүтээгдэхүүний оролцоо өндөр байгаа бол зарим аймгуудад хэдийгээр нэг хүнд ногдох ДНБ-ийн хэмжээ өндөр ч тээвэр, мэдээлэл холбооны салбарт оногдох хувь багатай байгаа зэргийг харгалзан хөрөнгө оруулалт, үйл ажиллагааны урьдчилсан тооцоо судалгааг хийж төлөвлөх нь үр дүнтэй байхаар байна.

Хүснэгт-5: Нэг хүнд ногдох ДНБ-д эзлэх тээвэр, мэдээлэл, холбооны салбарын оролцоо. Эх сурвалж: ҮСХ-ны статистикийн мэдээллийн нэгдсэн сан

Аймаг	Нэг хүнд ногдох ДНБ (мянган төг.)				ДНБ-д эзлэх Тээвэр, мэдээлэл, холбоо салбарын хувь				Нэг хүнд ногдох ДНБ-д эзлэх ТМХ салбарын оролцоо (мянган төг.)
	2016	2017	2018	2019	2016	2017	2018	2019	
Архангай	3,962.8	4,438.5	4,518.9	5,875.64	1.3%	1.4%	1.4%	1.1%	64.1
Баян-Өлгий	3,115.3	3,253.1	3,612.2	3,946.98	4.8%	5.6%	5.0%	4.5%	178.2
Баянхонгор	4,119.4	4,633.2	4,756.9	5,636.05	2.5%	2.7%	2.8%	2.5%	141.7
Булган	4,649.7	4,635.4	5,145.	5,867.24	0.9%	1.1%	1.1%	0.9%	54.0

Говь-Алтай	4,392.8	4,663.4	5,589.1	5,882.65	0.9%	1.0%	0.9%	0.9%	50.5
Говьсүмбэр	5,015.	4,890.7	5,110.4	6,463.8	<b>0.4%</b>	<b>0.4%</b>	<b>0.5%</b>	<b>15.8%</b>	1,023.2
Дархан-Уул	3,921.9	4,061.4	4,157.3	5,499.64	<b>2.9%</b>	<b>3.2%</b>	<b>3.0%</b>	<b>11.6%</b>	639.8
Дорноговь	4,197.8	4,392.	5,347.8	5,840.91	<b>12.6%</b>	<b>12.3%</b>	<b>10.1%</b>	<b>9.8%</b>	571.2
Дорнод	8,778.6	10,162.5	10,355.1	11,446.73	0.7%	0.7%	1.1%	<b>0.7%</b>	77.9
Дундговь	5,041.	5,618.8	7,044.6	8,199.13	1.9%	2.1%	1.6%	1.4%	114.0
Завхан	4,236.7	4,359.5	4,911.	5,785.	3.4%	4.1%	3.6%	3.1%	180.9
Орхон	11,063.6	16,884.2	18,270.2	20,316.93	1.2%	0.9%	1.0%	<b>0.8%</b>	167.3
Өвөрхангай	3,584.6	4,009.7	4,322.4	5,286.22	2.3%	2.5%	3.0%	2.8%	149.0
Өмнөговь	6,463.1	11,050.8	9,762.2	11,870.49	<b>5.2%</b>	<b>3.4%</b>	<b>7.4%</b>	<b>8.2%</b>	971.7
Сүхбаатар	5,557.6	6,817.8	8,088.	8,574.66	0.8%	0.6%	0.7%	0.7%	57.8
Сэлэнгэ	5,254.7	5,553.3	6,325.7	7,398.87	<b>2.4%</b>	<b>2.8%</b>	<b>2.5%</b>	<b>7.5%</b>	558.3
Төв	5,592.8	5,450.8	6,272.1	7,241.66	0.5%	0.7%	0.6%	0.2%	17.1
Увс	3,705.	3,889.2	4,672.	5,019.17	2.0%	2.4%	2.2%	2.2%	109.2
Ховд	3,655.7	3,778.5	4,377.	4,461.69	3.2%	4.0%	3.6%	3.9%	172.9
Хөвсгөл	3,815.2	3,908.4	4,632.4	5,348.62	1.8%	2.3%	2.0%	1.7%	91.0
Хэнтий	4,557.5	4,589.5	5,521.1	6,491.9	0.9%	1.2%	1.0%	1.0%	67.9
Улаанбаатар	11,519.7	12,940.7	15,031.	16,960.09	<b>10.1%</b>	<b>9.4%</b>	<b>8.8%</b>	<b>8.4%</b>	1422
Улсын дүн	7,910.	8,999.1	10,259.8	11,680.62	<b>7.4%</b>	<b>6.9%</b>	<b>6.7%</b>	<b>6.6%</b>	774

Радиоогийн үйлчилгээний онцлог давуу тал, хэрэглэгчийн зах зээлийн ялгаатай байдал болон технологийн хөгжлийн чиг хандлага, бусад медиа салбарын шилжилтийн туршлагаас сургамж авах зэрэг нөхцөл байдлыг харгалзан радиоогийн зах зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх, зах зээлд үр ашигтай үйл ажиллагаа эрхлэх, хамтдаа хөгжих нөхцөл боломж манай улсын хувьд байгаа гэж хэлж болохоор байна.

Өргөн нэвтрүүлгийн тухай хууль батлагдан гарсанаар өргөн нэвтрүүлгийн зах зээлд шударгаар өрсөлдөх нөхцөл бүрдэх суурь зарчим бүрдэж бие даасан үйлчилгээний зохицуулалтын орчин бий болж байгаагийн зэрэгцээ өргөн нэвтрүүлгийн үйлчилгээг салбарын бусад харилцаа холбоо, мэдээллийн технологийн үйлчилгээний статистик үзүүлэлт, тоо баримттай харьцуулан авч үзэх, статистик мэдээллийн суурь судалгаа бий болох хууль зүйн үндэс тавигдаж, үйлчилгээ эрхлэгчдийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулах ач холбогдолтой болж байгаа юм.

Харилцаа холбооны зохицуулах хорооноос хэт богино долгионы радиоогийн үйлчилгээний зах зээл, хүртээмж, тоон технологийн шилжилтийн чиглэлээр судалгаа, мэдээллийг гаргаж ажиллахыг зорьж байгаа бөгөөд эдгээр нь салбарын статистик үнэн зөв байх, үйлчилгээ эрхлэгчдэд зах зээлд өрсөлдөх, хөрөнгө оруулалт, тооцоо судалгаа хийхэд шаардлагатай суурь мэдээлэл болно гэж итгэж байна.

*Ашигласан материал:*

- Technology, Media, and Telecommunications Predictions 2019 – Deloitte Development
- Communications Market Report 2020 – OFCOM
- Communications Marketplace Report 2020 – FCC
- Үндэсний Статистикийн Хороо: Статистикийн мэдээллийн нэгдсэн сан
- Харилцаа холбооны зохицуулах хороо: Статистикийн тайлан – 2019